

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/02/НА-СТА-3ГТС

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@auditgov.mn Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 261885 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn Ахлах аудитор: М.Пагамдулам Утас: 261628 Цахим хаяг: pagamdulamm@audit.gov.mn Аудитор Б.Отгонцэцэг Утас: 261628 Цахим хаяг: otgontsetsegb@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	7
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	8
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	8
4. АУДИТЫН ТАЙЛАН	10
4.1 Ерөнхий зүйл	10
4.2 Материаллаг байдал	10
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12
5.1 Албан шаардлага	12
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
МЗН	Мэс заслийн нийгэмлэг
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМС	Эрүүл мэндийн сайд



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/685
танай _____-ны № _____-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Д.ОЧИРБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Эрүүл мэндийг дэмжих сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/89, А/273, А/314, А/410 дугаар тушаалуудаар Монгол улсад эмчлэгдэх боломжгүй зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн 84 иргэнд, нийт 3,921,996.7 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/494 дүгээр тушаалаар Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд эрх шилжүүлж, өмнөх оноос шилжиж ирсэн иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэнд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах, нийт 588,826.0 мянган төгрөгийн 15 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн А/100 дугаар тушаалаар Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний тэргүүлэх чиглэлийг 6 үндсэн чиглэл, 13 арга хэмжээтэй байхаар шинээр баталсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,967,546,000.00	133,003,880.00
34	УРЬДЧИЛГАА	1,967,546,000.00	133,003,880.00
34600	Урьдчилж гарсан зардал	1,967,546,000.00	133,003,880.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	1,967,546,000.00	133,003,880.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,967,546,000.00	133,003,880.00
51	Засгийн газрын хувь оролцоо	1,967,546,000.00	133,003,880.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,967,546,000.00	133,003,880.00
51210	Өмнөх үеийн үр дүн	611,059,993.00	1,967,546,000.00
51220	Тайлант үеийн үр дүн	1,356,486,007.00	(1,834,542,120.00)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	1,967,546,000.00	133,003,880.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	5,790,128,150.00	3,921,996,999.83
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,810,100.00	3,921,996,999.83
120	Нийтлэг татварын бус орлого	4,810,100.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,810,100.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,810,100.00	-
122	Тусламжийн орлого	-	3,921,996,999.83
1221	Хандив тусламж /дотоод/	-	3,921,996,999.83
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	3,921,996,999.83
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	3,921,996,999.83
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,785,318,050.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,785,318,050.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,785,318,050.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,148,607,143.00	5,756,539,119.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,148,607,143.00	5,756,539,119.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,148,607,103.49	3,267,278,582.83
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,148,607,103.49	3,267,278,582.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,148,607,103.49	3,267,278,582.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39.51	2,489,260,537.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	257.68
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	257.68
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	257.68
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	257.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,489,260,279.32
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	2,489,260,279.32
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	39.51	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	39.51	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,641,521,007.00	(1,834,542,120.00)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,285,035,000.00	-

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	1,285,035,000.00	-
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(1,285,035,000.00)	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	1,356,486,007.00	(1,834,542,120.00)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	5,785,318,050.00	3,921,996,999.83
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	3,921,996,999.83
122	Тусламжийн орлого	-	3,921,996,999.83
1221	Хандив тусламж /дотоод/	-	3,921,996,999.83
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	3,921,996,999.83
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	3,921,996,999.83
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,785,318,050.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,785,318,050.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,785,318,050.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,785,318,050.00	3,921,996,999.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,785,318,050.00	3,921,996,999.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,785,318,010.49	1,432,736,462.83
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,785,318,010.49	1,432,736,462.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,785,318,010.49	1,432,736,462.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39.51	2,489,260,537.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	257.68
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	257.68
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	257.68
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	257.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,489,260,279.32
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	2,489,260,279.32
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	39.51	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	39.51	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	611,059,993.00	611,059,993.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	611,059,993.00	611,059,993.00
9	Тайлант үеийн үр дүн	-	-	1,356,486,007.00	1,356,486,007.00
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,967,546,000.00	1,967,546,000.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,967,546,000.00	1,967,546,000.00
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,834,542,120.00)	(1,834,542,120.00)
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	133,003,880.00	133,003,880.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,253,208,100.00	3,921,996,742.15	2,331,211,357.85	62.7
12	Татварын бус орлого	6,253,208,100.00	3,921,996,742.15	2,331,211,357.85	62.7
122	Тусламжийн орлого	6,253,208,100.00	3,921,996,742.15	2,331,211,357.85	62.7
122005	Төсвөөс санхүүжих	6,253,208,100.00	3,921,996,742.15	2,331,211,357.85	62.7
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,253,208,100.00	3,921,996,742.15	2,331,211,357.85	62.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,253,208,100.00	3,921,996,742.15	2,331,211,357.85	62.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,187,723,600.00	1,432,736,462.83	1,754,987,137.17	44.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,187,723,600.00	1,432,736,462.83	1,754,987,137.17	44.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,187,723,600.00	1,432,736,462.83	1,754,987,137.17	44.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,065,484,500.00	2,489,260,279.32	576,224,220.68	81.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,065,484,500.00	2,489,260,279.32	576,224,220.68	81.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,065,484,500.00	2,489,260,279.32	576,224,220.68	81.2
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрүүл мэндийг дэмжих сан нь Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр хүн амд боловсрол олгох, эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалтын ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлдэг байна.

Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг дараах чиглэлээр эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулж байна. Үүнд:

- Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэнд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа;
- Хүний эрүүл мэндэд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийг тандах, судлах үйл ажиллагаа;
- Эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх үйл ажиллагаа;
- Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх;
- Тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөлт нь хуульд заасан хугацааг хангаагүй амьгүй донорын гэр бүлийн гишүүнд олгох нэг удаагийн тэтгэмж;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Эрүүл мэндийг дэмжих сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль тогтоомжийг эрүүл мэндийн салбарын бодлого зохицуулах, хэрэгжүүлэх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны тэргүүлэх чиглэлийг шинэчлэн баталсан;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” шинэчлэн баталсан;

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үзлээ.

Эрүүл мэндийг дэмжих сангийн Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас эрүүл мэндийн яамны аппаратын 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/590 дүгээр тушаалаар баталсан НБББББ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,834,542.1 мянган төгрөгөөр буюу 93.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилгаа	1,967,546.0	133,003.9	(1,834,542.1)
Нийт хөрөнгө	1,967,546.0	133,003.9	(1,834,542.1)
Засгийн газрын хувь оролцоо	1,967,546.0	133,003.9	(1,834,542.1)
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,967,546.0	133,003.9	(1,834,542.1)

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 133,003.9 мянган төгрөгт хүрч 1,834,542.1 мянган төгрөгөөр буурахад өмнөх оноос шилжин он дамжин хэрэгжиж байгаа 17 төслийн 1,810,676.0 мянган төгрөг, он дамжин үлдэгдэлтэй байсан 58,510.0 мянган төгрөгийн 3 төсөл хөтөлбөр бүрэн хэрэгжиж дуусан нь нөлөөлсөн байна.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэлд Орхон аймгийн БОЭТ-өөс авах тендерийн хэмнэлтийн 34,643.9 мянган төгрөг, өмнөх онуудад санхүүжилт олгосон Бүдүүн шулуун гэдэсний бага гэмтэлтэй МЗН төслийн 37,350.0 мянган төгрөг, МҮОНРТ-ийн төслийн 35,810.0 мянган төгрөг, Ковер дизайн ХХК-ий төслийн 25,200.0 мянган төгрөг, нийт 133,003.9 мянган төгрөгийн урьдчилж гарсан зардал тус тус бүртгэлтэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2025 оны төсвийн төсөлд эрүүл мэндийг дэмжих сангийн төсвийг 15,826,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 6,114,100.0 мянган төгрөгөөр бууруулж, 9,711,900.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2024 оны архи, согтууруулах ундааны онцгой албан татварын орлогын 1.0 хувиар, архи, тамхи, эмийн импортын албан татварын орлогын 2.0 хувиар тооцож, төсвийн төслийг боловсруулсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 9,711,900.0 мянган төгрөгийн улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 3,458,691.9 мянган төгрөгөөр бууруулж, 1 удаа тодотгосон байна. Энэ нь тус дэмжих сангаас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 3 арга хэмжээний 3,458,691.9 мянган төгрөгийг хасаж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,921,996.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон нь төлөвлөснөөс 2,331,211.6 мянган төгрөгөөр дутуу байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,921,996.7 мянган төгрөг буюу 62.7 хувьтай байгаа нь зайлшгүй шаардлагаар гадаадад эмчилгээ хийлгэсэн иргэдэд олгосон санхүүгийн дэмжлэгт 3,921,996.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71601	Нийгмийн эрүүл мэнд	6,253,208.1	3,921,996.7	2,331,211.6	62.7
80605	Эрүүл мэндийг дэмжих	6,253,208.1	3,921,996.7	2,331,211.6	62.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрүүл мэндийг дэмжих сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой, бүрдэл дутуу баримтаар ажил, гүйлгээ бүртгэхгүй байх, зардлын ангилал зөрчиж зарцуулахгүй байх зэрэг нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор М.Пагамдулам, аудитор Б.Отгонцэцэг нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер В.Эрдэнэцогт, дараагийн шатны хяналтыг газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 3/351 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,148,607.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 31,486.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар нийт 1,221,850.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3 зөрчилд зөвлөмж өглөө.

4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим системд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн мэдээлж байх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.3.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

1. Тус сангийн хөрөнгөөр эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 16 төслийн сонгон шалгаруулалт, түүнээс гарсан үр дүнг цахимаар нээлттэй ил тод мэдээллэхгүй байгаа нь сонгон шалгаруулалтанд оролцогчдод давуу байдал бий болох, ашиг сонирхлын зөрчил үүсэх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2024 оны 78 дугаар тогтоолоор баталсан Эрүүл мэндийн дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах хяналт тавих журмын 3.3-т Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг бүртгэх, сонгон шалгаруулах, мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсөл, хөтөлбөрийн сонгон шалгаруулалт, түүнээс гарсан үр дүнг цахимаар нээлттэй ил тод мэдээлж байх.

2. ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газар нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлийг боловсруулж батлуулах талаар тусгаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2024 оны 78 дугаар тогтоолоор баталсан Эрүүл мэндийн дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах хяналт тавих журмын 4 дүгээр зүйлийн 4.1-д "Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх энэ журмын 3.1.1-3.1.3-т заасан арга хэмжээний тэргүүлэх чиглэлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зохицуулалтын чиг үүрэг хариуцсан нэгж боловсруулж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн жил бүр батална" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлийг боловсруулж батлуулах талаар тусгаж ажиллах.

3. Тайлант хугацаанд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшилтэд технологи нэвтрүүлэх чиглэлээр эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 1,221,850.0 мянган төгрөгийн 2 төслийн үр дүнг мэргэжлийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Засгийн газрын 2024 оны 78 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах хяналт тавих журам"-ын 5 дугаар зүйлийн 5.15-д "Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн үр дүнг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх тухайн чиглэлийн мэргэжлийн салбар зөвлөл хэлэлцэж, дүгнэлт гаргасан байна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ЭМДС-ийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшилтэд технологи нэвтрүүлэх чиглэлээр эрх шилжүүлж хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний үр дүнг салбар зөвлөлөөр хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулж байх албан шаардлага өглөө.

4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.4.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 улирлын санхүүгийн тайланг хамруулж, бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө, мөнгөн хөрөнгийн данстын хувьд горим, сорил хэрэгжүүлж, илэрсэн асуудлыг жилийн эцсийн аудитаар нэгтгэн дүгнэж асуудлын бүртгэлд тусгасан.

4.4.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн хариуцлага тооцох 1 албан шаардлага, 22,245.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмжийг тус тус бүрэн хэрэгжүүлж 114,560.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хэрэгжих шатанд, 35,810.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг төлөөгүй биелэлт 67.4 хувьтай байна. Үүнээс урьдчилж төлсөн зардалтай холбоотой Бүдүүн шулуун гэдэсний бага гэмтэлтэй МЗН-ийн 37,350.0 мянган төгрөгийн 1 төсөл, Ковер дизайн ХХК-ийн 25,200.0 мянган төгрөгийн 1 төсөл тус тус хууль хяналтын байгууллагад шалгагдаж байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	42,310.0	1	6,500.0	15.4
Албан шаардлага	2	136,805.0	2	74,205.6	54.2
Хариуцлага тооцох албан шаардлага	1	-	1	-	100.0
Зөвлөмж	1	-	1	-	100.0
Нийт дүн	6	179,115.6	4	80,705.6	67.4

Өмнөх оны аудитаар тогтоосон 35,810.0 мянган төгрөгийн төлбөрийн акт төлөгдөөгүй тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-г бүрэн хэрэгжүүлж байгааг шалгах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт өмнөх оны акт, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилттэй холбоотой нэг зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага өгсөн.

Аудитаар илрүүлсэн залруулагдаагүй алдаа зөрчил нь бидний тооцсон 31,460.0 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Харицлага тооцох албан шаардлага

Өмнөх оны аудитаар МҮОНРТ-ийн хэрэгжүүлээгүй “Алаг амьдрал” төслийн урьдчилгаанд олгогдсон 35,810.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон бөгөөд уг төлбөрийн актыг барагдуулах тухай албан бичгийг ЭМЯ-ны 2025 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 2/1807 дугаар бичгээр МҮОНРТ-д хүргүүлсэн бөгөөд төлбөрийн актыг барагдуулаагүй байна. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн актыг барагдуулаагүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага				
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
1	Өмнөх оны аудитаар МҮОНРТ-ийн хэрэгжүүлээгүй “Алаг амьдрал” төслийн урьдчилгаанд олгогдсон 35,810.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон бөгөөд тайлант хугацаанд Эрүүл мэндийн яам нь уг төлбөрийн актыг барагдуулах тухай албан бичгийг 2025 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 2/1807 дугаар бичгээр МҮОНРТ-д хүргүүлсэн боловч өнөөдрийг хүртэл төлбөрийн актыг барагдуулаагүй байна	1	-							1	1	-		
Нийт дүн		1	-							1	1	-		

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
		Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
1	Шилэн дансны цахим системд батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	-			1	-
Дүн		1	-			1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой							
2	Тус сангийн хөрөнгөөр эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 16 төслийн сонгон шалгаруулалт, түүнээс гарсан үр дүнг цахимаар нээлттэй ил тод мэдээлэхгүй байгаа нь сонгон шалгаруулалтад оролцогчдод давуу байдал бий болох, ашиг сонирхлын зөрчил үүсэх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлтэй байна.	1				1	-
3	ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газар нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлийг боловсруулж батлуулах талаар тусгаагүй байна.	1				1	-
4	Тайлант хугацаанд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшилтэд технологи нэвтрүүлэх чиглэлээр эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 1,221,850.0 мянган төгрөгийн 2 төслийн үр дүнг мэргэжлийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлж дүгнэлт гаргуулаагүй байна.	1	1,221,850.0	1	1,221,850.0		
Дүн		3	1,221,850.0	1	1,221,850.0	2	-
Нийт дүн		4	1,221,850.0	1	1,221,850.0	3	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 770/А0171275

Улаанбаатар хот

САГ-2026/02/НА-СТА-3ГТС

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар МҮОНРТ-ийн хэрэгжүүлээгүй "Алаг амьдрал" төслийн урьдчилгаанд олгогдсон 35,810,000.00 /гучин таван сая найман зуун арван мянга/ төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг Эрүүл мэндийн яамны 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 2/1807 дугаар бичгээр МҮОНРТ-д хүргүүлсэн, төлбөрийн актыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" гэсэн заалттай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн актыг барагдуулаагүй, төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох, биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/, Ерөнхий нягтлан бодогч /С.Цогзолмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
М.ПАГАМДУЛАМ
Б.ОТГОНЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 771/A0171275

Улаанбаатар хот

САГ-2026/02/НА-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшилтэд технологи нэвтрүүлэх чиглэлээр эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 1,221,850,000.00 /нэг тэрбум хоёр зуун хорин нэгэн сая найман зуун тавин мянга/ төгрөгийн 2 төслийн үр дүнг мэргэжлийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлж дүгнэлт гаргуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Засгийн газрын 2024 оны 78 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах хяналт тавих журам"-ын 5 дугаар зүйлийн 5.15-д "Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн үр дүнг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх тухайн чиглэлийн мэргэжлийн салбар зөвлөл хэлэлцэж, дүгнэлт гаргасан байна" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшилтэд технологи нэвтрүүлэх чиглэлээр эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 2 төслийн үр дүнг мэргэжлийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлж дүгнэлт гаргуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/, Ерөнхий нягтлан бодогч /С.Цогзолмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
М.ПАГАМДУЛАМ
Б.ОТГОНЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-45.Docx

1526181028